



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Нислэгийн мэдээллийн үйлчилгээ
үзүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, ИНД-172 “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийн 172.93 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын “Улаанбаатар” нислэгийн мэдээллийн бүсэд нислэгийн мэдээллийн үйлчилгээг зөвхөн өдрийн цагаар 5715 кгц ажлын давтамжтай Арцат төвөөс 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 08:00 цагаас эхлэн үзүүлсүгэй.

2.Нислэгийн мэдээллийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг зохих журмын дагуу зарлан мэдээлэх, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА